

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТАЛААРХ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьялах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүний тоо нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна гэснийг баримтлан Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны гишүүнээр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлаар Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа,

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

Б.ЧОЙЖИЛСҮРЭН



Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

**Дэд хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хорооны гишүүнээр баталсугай.
- 2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг